



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Партизаны гудамжк 6, Утас: 26 35 85, 26 35 79,
Факс: 26 35 47, И-мэйл: nationalcouncil@nema.gov.mn,
Вэбсайт: www.nema.gov.mn

2022. 10. 21 № 2/01

таний _____ -ны № _____ -т

Үүрэг хүргүүлэх тухай

Тус зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит хуралдаанаас гарсан цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай дараах арга хэмжээг салбарын түвшинд онцгойлон анхаарч өндөр хариуцлагатай хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгч байна. Үүнд:

Нэг: Санхүү хөрөнгө оруулалт, эдийн засаг, хөгжлийн салбар

Хууль зүй дотоод хэргийн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд:

1. Болзошгүй гамшгийг хохирол багатай даван туулах төсөв санхүүгийн нөөцийг бүрдүүлж, эрсдэлийн санг улс орон нутгийн түвшинд байгуулах эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.1, 51.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэх, төсвийн зардлын ангилал, зэрэглэлийг бий болгох чиг үүрэг бүхий түр Ажлын хэсгийг байгуулж, нөлөөллийн тооцоо судалгаа, хуулиудын уялдаа холбоог нарийвчлан судалж, санал дүгнэлт боловсруулж Үндэсний зөвлөлийн ажлын албанад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх, Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулах. /Сангийн яам/

2. "Гамшгийн эрсдэлийн даатгалын тухай хууль" боловсруулах үндсэн чиг үүрэгтэйгээр байгуулагдсан (Сангийн сайдын 2022 оны 60 дугаар тушаал) ажлын хэсгийн явц, үр дунд тусгайлан хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд өргөтгэн шинээр байгуулж, Азийн хөгжлийн банкны ТА9880 техник туслалцааны төслийн хуулийн зөвлөх багийн ажлын үр дүнг тооцож, холбогдох эдийн засгийн тооцоо, тандан судалгаанд үндэслэн хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийн танилцуулгыг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Үндэсний зөвлөлийн ажлын албанад тайлагнах. /Сангийн яам/

3. Гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүү, төсөв, зээл тусlamжийн олон өөр арга хэрэгслийг нэвтрүүлж иргэдийн амжиргаа, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор "Гамшгийн санхүүжилтийн үндэсний стратеги"-ийн баримт бичгийг боловсруулахад шаардлагатай нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгаа, хууль эрх зүйн орчны шинжилгээг хийж, холбогдох санал дүгнэлтийг гаргаж Үндэсний зөвлөлийн ажлын албанад 2022 оны 11 дүгээр

сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх, Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд тайлагнах /Сангийн яам/

4. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн 2022 онд дэлхий нийтэд хандан гаргасан “Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, эрт зарлан мэдээллийг ирэх 5 жилийн дотор дэлхийн иргэн бүрт хүртээмжтэй хүргэх” тухай уриалгыг дэмжиж, “Монгол Улсад гамшгийн аюулыг зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн төслийн явцыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам/

5. Гамшгийн үед нийлүүлэлтийн сүлжээ доголдсон, тасарсан үед хүн ам, айл өрхийн хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд “Улаанбаатар хотод 2.0 мян.тн багтаамжтай хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь”, “20.0 мян.тн хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барих”, мөн гамшгийн үед ажиллах техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зориулалт бүхий “Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний 20.0 метр.куб-ын багтаамжтай терминал байгуулах” зэрэг томоохон төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлд шаардлагатай төсвийн эх үүсвэрийг төсвийн болон зээл тусламжийн санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэх арга замыг судалж, энэ талаарх судалгаа тооцоог тодорхой саналтайгаар Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдаанд танилцуулах /Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам/

Хоёр. Цахим хөгжил, харилцаа холбооны салбар

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд:

1. Гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг хөгжүүлэх, гамшгийн урьдчилан сэргийлэх эрсдэлийн харилцаа холбоог олон нийтэд хүртээмжтэй хүргэх технологийн арга шийдлүүд, тухайлбал и-монголиа платформ, өргөн нэвтрүүлгийн сүлжээ, гамшиг, аюулт үзэгдлийг амжиж анхааруулах системийг хууль эрх зүй, технологийн талаас сайжруулан бэхжүүлж, харилцан уялдааг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээний саналыг Үндэсний зөвлөлийн ажлын албанад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж, Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулах.

2. Гамшгийн үед хор уршгийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор замын хөдөлгөөний цахим хяналтын удирдлагын системийн ажлыг бүрэн хийж дуусгах судалгаа, тооцооны саналыг Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн Ажлын албанад 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулах.

3. Монгол Улсын хэмжээнд радио, өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлж, Хонхорын Радио өргөн нэвтрүүлэх төвд тоон радиогийн 400квт чадлын нэвтрүүлэх станц байгуулах төслийг шуурхай эхлүүлэх, хэрэгжүүлэхэд онцгойлон

анхаарал хандуулж, гамшиг, аюулт үзэгдэл, цаг агаарын урьдчилсан мэдээг улсын хэмжээнд дахин дамжуулах нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх.

Гурав. Боловсрол шинжлэх ухаан, технологийн салбар

Боловсрол, шинжлэх ухааны яаманд:

1. “Аюулгүй амьдрах ухаан”, “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт гамшигийн аюулаас өөрийгөө болон бусдыг авран хамгаалах сургалтын агуулгыг нэмэгдүүлэх, боловсролын бүх шатанд заах арга зүйн сургагч багш нарыг аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд бэлтгэх.

2. Сургуулийн орчинд гамшигийн үед дохио дамжуулах боломжийг бүрдүүлэх, яаралтай цугларах талбай, стандартын шаардлага хангасан хордох байр, гамшигийн анхан шатны нөөцийг бүх шатны боловсролын байгууллагуудад хангах тооцоо судалгааг гаргаж, Үндэсний зөвлөлийн ажлын албанад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлж, зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулах.

3. Гамшигийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дэргэд “Шинжлэх ухаан технологи, инновацийн салбар зөвлөл байгуулах бэлтгэл ажлын явцыг үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулах. /Шинжлэх ухааны академи, ОБЕГ/

Дөрөв. Эрчим хүч, зам тээвэр, барилга хот байгуулалтын дэд бүтцийн салбар

1. Эрчим хүчний түгээх сүлжээ, дулаан, цахилгааны дамжуулах сүлжээнд гамшигийн эрсдэлийн үнэлгээг системийн түвшинд хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг нарийвчлан тодорхойлж танилцуулах /Эрчим хүчний яам/

2. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн хуулиуд, холбогдох барилга, дэд бүтцийн норм стандартуудад гамшигийн эрсдэлийг тооцох, гамшигийг тэсвэрлэх чадавхыг үнэлэх, хяналт тавих тогтолцоог бэхжүүлж, уялдаа холбоог хангах ажиллах /Барилга, хот байгуулалтын яам/

Тав: Гадаад харилцаа, хамтын ажиллагааны салбар

1. Зүүн-Хойд Азийн бүс нутагт гамшигийн үеийн хүмүүнлэгийн тусlamжийг зохицуулах, хадгалах, түгээх төвийг Бүянт-Ухаа нисэх буудлыг түшиглэн байгуулах санаачилгын мөрөөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшигийн эрсдэлийг бууруулах газар, Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах албатай холбогдох шугамаар хамтран ажиллах.

Зургаа. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар

1. Мал аж ахуй, газар тариалангийн салбарт шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчлах, малчид тариаланчдад сургалт нөлөөллийн арга хэмжээг анхан шатанд зохион байгуулах хөтөлбөр төлөвлөгөө бэлтгэн, танилцуулах.
2. Гамшгийн үеийн хүнсний хангамж, аюулгүй байдал, шим тэжээллэг чанарыг хадгалах зорилгоор гамшигт тэсвэртэй хөдөө аж ахуй, удаан хадгалагдах хүнсний хангамжийн хадгалах, түгээх сүлжээний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар тодорхой саналыг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний зөвлөлийн ажлын албанд танилцуулах.

Долоо. Соёлын салбар

1. Улсын хэмжээнд музейн барилгууд, түүхийн дурсгалт газруудад гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, соёлын биет өвийг хамгаалах, барилга байгууламжийг хүчитгэн хамгаалах тооцоо судалгааг 2023 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулах.

2. Гамшгийн үед болон гамшгийн дараа соёлын биет өвийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэхэд мөрдөх журам, дүрэм, стандартын баримт бичгийг боловсруулах.

Найм. Эрүүл мэндийн салбар

1. Нийгмийн эрүүл мэнд, халдварт өвчний үед ашиглах шуурхай удирдлагын байр, цар тахлын үед ашиглах тусгай зориулалтын байгууламжууд, тэдгээрт шаардлагатай техник тоног төхөөрөмж, нөөцийг бүрдүүлэх тооцоо судалгааг бэлтгэн үндэсний зөвлөлийн ажлын албанд 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх, зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд танилцуулах.

2. Гамшиг тохиолдсон үед нэрвэгдсэн, бэртэж гэмтсэн, өрхийн гишүүдээ алдсан иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх сургагч багш нарыг сайн дурын иргэдийн оролцоотой бэлтгэж, бэлтгэгдсэн иргэдийг бүртгэж, сайн дурын сэтгэл зүйч нарын нөөцийг улсын хэмжээнд бүрдүүлж, бэлэн байдлыг хангахад шаардлагатай тооцоо судалгааг ээлжит Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

Ес. Байгаль орчин аялал жуулчлалын салбар:

1. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөөн үлдсэн ойн сан бүхий бүсийг түймрийн аюулаас хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нутгийн иргэдийн оролцоо, урамшууллын тогтолцоог бий болгох, анхан шатанд гал унтраах сайн дурын хэсэг бүлгийг байгуулж, аймаг, сум, багийн түвшинд ой, хээрийн түймэр унтраах материал техникийн нөөц бүрдүүлэх чиглэлээр тооцоо судалгаа гаргаж, танилцуулах.

Арав. Барилга, хот байгуулалтын салбар:

1. Газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийгдээгүй 9 аймаг (Булган, Говь-Алтай, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл)-т зураглал хийхэд шаардагдах зардлыг үе шаттай шийдвэрлэж хэрэгжүүлэх.

2. 2023 онд паспортжуулах барилга, байгууламж болон газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан хүчигтэх, шинээр барих барилгад шаардагдах зардлыг шийдвэрлэх, гүйцэтгэх.

Арван нэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлд:

1. Аймаг, орон нутгийн хүн амын 10-аас доошгүй хувьд гамшгаас хамгаалах чиглэлээрх сургалтыг зохион байгуулах, шаардлагдах төсвийг 2023 оны төсөвт тусгаж шийдвэрлэх.

2. Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэл, дүүрэг, 21 аймгийн салбар зөвлөлийг 2023 оны улсын төсөв батлагдсантай холбогдуулан 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан хуралдуулах.

3. “Өсвөрийн аврагч бүлгэм”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, чадавхжуулах, аймаг бүр 3-аас доошгүй сумын ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт арга зүйн танхим байгуулахад дэмжлэг үзүүлэх.

Арван хоёр. Үндэсний зөвлөлийн ажлын албанд:

1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн дараагийн хуралдааныг 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, үндэсний зөвлөлийн гишүүд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр өгсөн дээрх үүргийн биелэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэн нарийвчлан төлөвлөж, биелэлтийг гишүүд биечлэн танилцуулах.

ШАДАР САЙД,
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА С.АМАРСАЙХАН

